



**EDUCATION
IN RUSSIA**



ОРОС УЛСАД ДЭЭД БА ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ДУНД БОЛОВСРОЛЫГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ЭЗЭМШИХ ХҮСЭЛТЭЙ ИРГЭДИЙН АНХААРАЛД!

ОХУ-ын Засгийн газрын тэтгэлэгт 2026/27 оны хичээлийн жилд гадаадын иргэд, харьяалалгүй иргэд, гадаадад оршин суугаа эх орон нэгтнүүдийг ОХУ-д суралцуулах сонгон шалгаруулалтын журам

Сонгон шалгаруулалтын бүртгэл ОХУ-ын мэдээллийн системд гадаад иргэдийн боловсролын (<https://education-in-russia.com/>) цахим хаягаар 2025 оны 9-р сарын 15-ны өдрөөс 2026 оны 01-р сарын 15 хүртэл үргэлжилнэ!

Сонгон шалгаруулалтад оролцох болзол.

Сонгон шалгаруулалтад дараах хүмүүс оролцож болно. Үүнд:

- ✓ Гадаадын иргэн (иргэн нь болох улсынхаа өмнөөс мэдүүлгээ өгч болно);
- ✓ Иргэншилгүй хүмүүс (мэдүүлгээ оршин суух зөвшөөрлийн дагуу амьдарч буй тухайн улсаас ирүүлнэ);
- ✓ Монгол улсад байнга оршин суудаг болон давхар иргэншилтэй эх орон нэгтнүүд
 - Зөвхөн ОХУ-ын иргэншилтэй эх орон нэгтнүүд сонгон шалгаруулалтад оролцох эрхгүй
 - 2025-2026 онд ОХУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагад суралцаж төгсөх ангийн сурагч, оюутан байх ёсгүй.

Сонгон шалгаруулалт хоёр үе шаттай явагдана. Үүнд:

Нэгдүгээр үе шат-Россотрудничество агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газар явуулна

Нэгдүгээр үе шатанд оролцохын тулд:

- ✓ Заасан хугацаанд мэдээллийн education-in-russia.com системд бүртгүүлэх (энэ нь 2025 оны 9-р сарын 15-аас 2026 оны 1-р сарын 15-ны өдрийг дуустал орон нутгийн цагаар 23:59 цаг хүртэл нээлттэй байна);
- ✓ Анкетаа үнэн, зөв бөглөж (мэдүүлгийг бөглөх зааварчилгаа <https://www.facebook.com/RussianhouseMongolia/videos/881260919868649>, <https://www.facebook.com/RussianhouseMongolia/videos/242802595402240/>) Оросын их, дээд сургуулиудын хүссэн боловсролын нэг хөтөлбөрийг сонгох (6 хүртэлх их дээд сургуулийн нэрсийг суралцах хүсэлтийн дагуу жагсаах);

Анкетанд дараах зүйлийг хавсралтаар оруулах:

- ✓ Нэгдүгээр үе шатанд оролцоход шаардагдах орос хэлэнд хөрвүүлсэн баримт бичгийн скан-хуулбарыг хавсаргах (**Хавсралт 1**).
- ✓ Анкет бөглөж тогтоосон хугацаанд хэлэлцүүлгэд явуулах. “Ноорог” статус буюу төлөвтэй анкетыг хүлээн авахгүй болохыг анхаарна уу!

Горилогчид зөвхөн нэг чиглэл/мэргэжлээр боловсролын нэг түвшинд суралцахаар сонгон шалгаруулалтанд оролцно.



EDUCATION
IN RUSSIA



Чухал!

Сонгон шалгаруулалтанд сайн дүн бүхий боловсролын гэрчилгээтэй горилогчдыг оруулна. Гэрчилгээнд мэргэжлийн бус 1-2 хичээл «дунд» үнэлгээтэй байж болно (Хавсралт 1.1.)

Горилогч өөрийн тухай хуурамч эсвэл дутуу мэдээлэл ирүүлсэн тохиолдолд горилогчийн нэгдүгээр шатны дүнг хүчингүйд тооцон баримт бичгийг хоёрдугаар шатанд оруулахгүйгээр татаж авна.

ОХУ-ын Засгийн Газрын тэтгэлэгт хуваарийн дагуу 2026/2027 оны хичээлийн жилд суралцуулах гадаадын иргэн, иргэншилгүй хүмүүс, гадаадад амьдарч байгаа эх орон нэгнүүдийн сонгон шалгаруулалтыг боловсролын гэрчилгээ, дүн, портфолио (ололт амжилт) болон видео танилцуулга ярилцлагыг тавигдах шаардлагын дагуу шалгаруулах гэсэн зарчмаар явуулна

Анкетаа мэдээллийн education-in-russia.com системд амжилттай оруулсан

горилогчийн баримт бичгийн бүрдүүлбэрийг тогтоосон хугацаанд оросын тэргүүлэх их сургуулиудын төлөөлөгчөөс бүрдсэн Экспертын комисс судлаж ажиллана.

Экспертын комисс нь баримт бичгийн бүрдүүлэлтийг судлаж ажиллахдаа дараах зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

- “Мэргэжлийн, боловсролын гэрчилгээ, дүн” -ийн шалгаруулалт

Боловсролын үнэмлэхийн дундаж оноо ба голлох хичээлийн онооны нийлбэр (Хавсралт 1.1.)

• Портфолио шалгаруулалт* (Хувийн амжилтын үнэлгээ). Хувийн амжилтын оноог сүүлийн 2 жилд гаргасан амжилтанд ногдуулна.

Хувийн амжилтын үнэлгээг горилогчийн соёл, спорт, эрдэм шинжилгээний хурал, нийгмийн чухал ач холбогдол бүхий арга хэмжээ, төсөл, уралдаан, чуулга, бага хурал зэрэгт оролцсон түвшинөөр үнэлнэ. Үүнд:

- Олон улсын түвшин

- Бүс нутгийн түвшин

- Улсын түвшин

- Орон нутгийн түвшин

- Орон нутаг хотын түвшинөөс доош амжилт (тухайлбал сургуулийн диплом)-ыг үнэлгээнд тооцохгүй

- эрдэм шинжилгээ боловсролын олимпиадад оролцсон байдал (Хавсралт 2)

- * энд ялагч /шагналтан/-ны медаль эсвэл дипломтой тохиолдолд сүүлийн 2 жилийн амжилтыг тооцно

- Олон улсын хэмжээний соёл, спортын тэмцээн (олимпиад, уралдаан, наадам)-ийн ялагч эсвэл шагналтан мөн болохыг нотлох баримт бичиг, олон улсын спортын мастерын үнэмлэх ирүүлсэн горилогчид сонгон шалгаруулалтын нэгдүгээр шатыг амжилттай давсанд тооцогдож нэмэлт шалгалтаас чөлөөлөгднө.

Мөн түүнчлэн дараах зүйлийг тооцож үнэлгээ өгнө

- Горилогчийн анкетанд юуны өмнө нэгдүгээрт тавьсан их дээд сургуулиас ирүүлсэн горилогчийг дэмжсэн албан тоот-өргөдөл. Гэхдээ түүнийг тухайн боловсролын байгууллагын тэргүүн эсвэл түүний орлогчийн гарын үсгээр баталгаажуулсан байна.



**EDUCATION
IN RUSSIA**



- Эрдэм шинжилгээний нийтлэлүүд ашигласан ном зүйн мэдээллийн хамт. 5-аас дээшгүй тооны нийтлэлд үнэлгээ өгнө (ординатур, магистратур, аспирантур зэрэг түвшинд суралцах горилогчдын хувьд);

- Өмнөх боловролыг “онц сайн” дүнтэй эзэмшсэнийг нотлох баримт бичиг
- Спортын дэд мастер (улсын түвшний) цолыг нотлох үнэмлэх (гэрчилгээ)-тэй байх

Баримт бичгийн бүрдүүлбэрийг судлах явцад Олимпиадын ялагч, шагналтуудын дипломыг харгалzan үзэх болно гэдгийг анхаарна уу!

“Архитектур-уран барилга” болон “Дизайн ” мэргэжлээр элсэж буй горилогчдын анхааралд!

“Архитектур-уран барилга” болон “Дизайн ” мэргэжлээр элсэх хүсэлтэй горилогчид анкетаа бөглөхдөө дараах зургийг А-4 хэмжээтэй цаасан дээр зурж (шугам зураг, гар зураг, зохиомж зэрэг) хавсралтаар ирүүлэх шаардлагатай:

1. Өнгөт харандаа, гуашь, усан будаг зэргээр зурсан бүтээл (байгалийн зураг, натюроморт)
2. Биет зүйлсийн дүрс (харандаан зураг)-тойрог, тэгш өнцөгт эсвэл квадрат (хайрцаг эсвэл лааз гэх мэт)
3. Циркуль, шугам гэх мэт хэрэгсэл ашиглаж хийсэн объектын зураг

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН КАМПАНИТ АЖЛЫН ХУВААРЬ

Бакалавр, магистр, аспирантур, ординатур*, орос хэлний Зуны сургуульд* суралцах хүсэлтэй горилогчид дараах үе шатыг амжилттай давах ёстой. Үүнд:

	2025.09.15- 2026.01.15	https://education-in-russia.com/ сайт дээр заавал бүртгүүлэх. <u>Хавсралт 1-д</u> заасан жагсаалтын дагуу хувийн баримт бичгийн скан-хуулбарыг байршуулах
	2025.09.15- 2026.01.23	Бүртгэлийн комисс ирүүлсэн мэдүүлгийг шалгах;
I	Анхаар!	Голлох хичээлд «С» буюу «дунд» үнэлгээ бүхий боловсролын гэрчилгээтэй горилогчдыг сонгон шалгаруулалтанд оруулахгүй болно; 1-2-р ангийн оюутнууд ерөнхий дунд боловсролын аттестат ба тухайн их дээд сургуулийн сургалтын хэлтсийн тамга бүхий сурлагын тодорхойлт (дундаж оноо нь 2.8, оросын боловсролын стандартаар бол 4-өөс доошгүй байна)-ыг тус тус гаргаж ирүүлнэ. Магистр, аспирантурд суралцах горилогчдын дипломны дундаж оноо нь монголын боловсролын стандартын стандартын стандартыар 2.8, оросын боловсролын стандартыар 4-өөс доошгүй байна. Тухайн мэргэжлийн голлох хичээлийн жагсаалтыг эндээс үз. <u>Хавсралт 1.1.</u>
	2025.09.15- 2026.01.23	Горилогчийн баримт бичгийн бүрдүүлбэрийг бэлтгэн сонгон шалгаруулалтанд оруулахаар Ажлын хэсэгт илгээх
II	2025.09.15- 2026.02.06	Ажлын хэсгийн гишүүд элсэлтийн шалгалтыг явуулах. <u>Хавсралт 3</u> Анхаар! Бүртгэл дуусгавар болж сонгон шалгаруулалт эхэлсний дараа горилогчийн сонгосон сургалтын чиглэл/ мэргэжлийг солих, мөн түүнчлэн боловсролын байгууллагуудын жагсалтанд өөрчлөлт оруулахыг хориглоно



	2026.02.10	Сонгон шалгаруулалтын 1-р шатыг амжилттай давсан горилогчдын эцсийн нээрсийг Русский Дом в Улан-Баторе-ийн Faceebok сошиал сүлжээн дэх https://www.facebook.com/RussianhouseMongolia хуудсанд байршуулна.
III	2026.02.10- 2026.02.13	Сонгон шалгаруулалтын дунд гаргах гомдлын шаардлага. Сонгон шалгаруулалтын дунд гаргах гомдлын шаардлагыг ГИС ОРФИ https://education-in-russia.com/ платформ руу шалгаруулалтын дун гарсаны дараа хуанлийн З хоногийн дотор гаргаж өгнө Сонгон шалгаруулалтын явцад гарсан зөрчил эсвэл шударга бус явуулсан тухай асуудлын талаар гаргах горилогчийн гомдлын шаардлагыг хэвлэмэл эсвэл гар бичмэлээр /сканирдсан/гэрэл зураг буулгасан баримт/ Россотрудничество агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын mongol@rs.gov.ru цахим хаягаар ирүүлнэ (гомдлын шаардлагад өргөдөл гаргачийн овог, эцэг эхийн нэр, нэр, горилогчийн бүртгэлийн анкетанд орсон паспортын дугаар, холбоо барих утас, горилогчийн мэдүүлгийн дугаар болон юуг зөвшөөрөхгүй байгаа тухай дэлгэрэнгүй бичих). Зохих ёсоор бүрдүүлэгүй (нэг эсвэл хэд хэдэн зүйл ороогүй) мэдүүлгийг комисс хүлээн авахгүй болно.
	2026.02.13- 2026.02.16	Гомдлын шаардлагыг хэлэлцэх. Гомдлын шаардлагыг хангах эс хангах талаар гаргасан комиссийн шийдвэр эцсийн байна.
IV	2026.02.10- 2026.02.18	Сонгон шалгаруулалтын нэгдүгээр шатыг амжилттай давж хоёрдугаар шатанд оролцох горилогчдын баримт бичгийн бүрдүүлбэрийг https://education-in-russia.com системд оруулах. /Хавсралт 4/
	2026.02.18- 2026.02.26	Горилогчдын баримт бичгийн бүрдүүлбэрийн чанар хийгээд баримт бичиг бурэн орсон эсэхийг бүртгэлийн комисс шалгах
V	2026.02.27	Гадаадын иргэдийн дунд явуулсан сонгон шалгаруулалтын нэгдүгээр шатны дунг Россотрудничество агентлагийн төв аппарат руу явуулах
VI	2026.03.01- 2026.05.01	2026/27 оны хичээлийн жилд ОХУ-ын Засгийн Газрын тэтгэлэгээр Оросын Холбооны Улсад суралцах гадаадын иргэн, иргэншилгүй хүмүүс болон гадаадад амьдарч буй эх орон нэгтнүүд (хоёрдахь иргншилтэй)-ийн дунд явуулсан сонгон шалгаруулалтын нэгдүгээр шатны дунг Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөл, гадаадад суугаа эх орон нэгтнүүдийн асуудал эрхэлсэн бололн олон улсын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны Холбооны агентлаг /Россотрудничество/-д хэлэлцэх, нэгдүгээр шатны дунг Оросын Боловсрол шинжлэх ухааны яаманд явуулах
VII	2026.03.01- 2026.08.30	Сонгон шалгаруулалтын явуулах- горилогчдын анкетын дагуу давын өмнө суралцахаар оруулсан сургуулиар ээлжлэн хэлэлцэх
VIII	2026.03.01- 2026.08.05	Урлагийн чадвар, бие бялдар эсвэл сэтгэл зүйн зохих чадвар шаардсан тусгай мэргэжил /бэлтгэлийн чиглэл, мэргэжил/-аэр суралцах горилогчдоос урлаг хийгээд мэргэжлийн онцлог чиглэлээр нэмэлт элсэлтийн шалгалтыг боловсролын байгууллагуудад өгөх Урлаг хийгээд мэргэжлийн онцлог чиглэлээр нэмэлт элсэлтийн шалгалт авах хуваарийг навигатор /чиглүүлэгч/-ын "Образование в Российской Федерации для иностранцев" хэмээх үндсэн хуудас https://russia-edu.mnобрнауки.gov.ru/ , болон улсын платформ https://education-in-russia.com/ дээрх хувийн кабинетад байршуулсан байна.



**EDUCATION
IN RUSSIA**



*Ординатур ба Орос хэлний Зуны сургуульд суралцах горилгчдод заавал тавихдах шаардлага— орос хэлийг чөлөөтэй эзэмшсэн байх.

*Ноорог байдлаар бичсэн мэдүүлгийг авч хэлэлцэхгүй

Анхаар!

Хуурамч мэдээлэл ирүүлсэн горилогчдыг уралдааны жагсаалтаас хасна

Зөвлөх комиссийн ажлын хуваарь:

Даваа-пүрэв гарагууд	09:00 цагаас 18:00 цаг хүртэл
Баасан гараг	09:00 цагаас 17:00 цаг хүртэл
Үдийн завсарлага	13:00 цагаас 14:00 цаг хүртэл

Харилцах утас: 11 45-38-90, 11 45-46-00

Хавсралт 1

БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Горилогч нь өөрийн хувийн мэдээллийг гадаад иргэдийн улсын бүртгэлийн системын <https://education-in-russia.com/> платформ дээр бие даан бүртгүүлнэ.

2. Мэдүүлэгт баримт бичгийн эх хувийн скан хуулбар ба түүний орос хэлэнд хөрвүүлсэн орчуулгыг хавсрагах (баримт бичгийн орчуулгыг орчуулгын товчоогоор баталгаажуулсан байна):

3. Гадаад паспорт – горилогчийн паспортын хүчинтэй байх хугацаа нь орох урьдчилсан товолсон хугацаанаас хойш 1,5 жилээс багагүй байна (2027 оны 3-р сарын 1). Баримт бичгийг орос хэлэнд орчуулж орчуулгын товчооны тамгаар баталгаажуулсан байх шаардлагатай. (Хэд хэдэн улсын иргэн бол бүх паспортын скан хуулбарыг гаргаж өгнө)

! МОНГОЛ УЛСАД БАЙНГА ОРШИН СУУГАА ХОЁР ИРГЭНШИЛТЭЙ ЭХ ОРОН НЭГТНҮҮД (ЗӨВХӨН ОХУ-ЫН ИРГЭНШИЛТЭЙ ЭХ ОРОН НЭГТНҮҮД СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРОХ БОЛОМЖГҮЙ) ДАРААХ ЗҮЙЛИЙГ ГАРГАЖ ӨГНӨ. ҮҮНД:

- Оросын Холбооны Улсын иргэний паспорт (дотоодын иргэний паспорт)-ын скан хуулбарыг гаргаж өгөх бөгөөд энэ нь горилогч нь элсэлтийн кампанит ажил эхэлсэн тухайн жилийн 9-р сарын 1-ний байдлаар ОХУ-д бүртгэл байхгүйг гэрчилнэ;

- Оросын Холбооны Улсын иргэний паспортгүй тохиолдолд тухайн горилогч нь эхэвчлэн гадаадад амьдарч байсныг гэрчлэх гадаад паспортын бүх хуудасны хуулбарыг гаргаж өгнө.



**EDUCATION
IN RUSSIA**



Горилогч нь дараалан үргэлжлэх 12 сарын туршид Оросын Холбооны Улсад хуанлийн 183 хоногоос цөөн хугацаагаар байсныг нотлох улсын хил нэвтэрч байсан тухай тэмдэглэл.

Баримт бичгийн дүрсэд хэвлэсэн цаасны зах орсон байвал зохино. Хуудасны зах бол баримт бичгийн салшгүй хэсэг бөгөөд захыг хайчлахыг хориглоно. Оруулж буй бүх баримт бичгийн дүрс чанартай (тод) байж баримтын агуулгыг ойлгоход төвөггүй уншигдаж байвал зохино.

• БОЛОВСРОЛЫН ҮНЭМЛЭХНИЙ ХУУЛБАР

- Диплом/аттестатын хамт үзсэн хичээл, сурлагын дүн бүхий нотариатаар батлуулсан орос хэлний орчуулгатай хавсралтыг ирүүлэх.
- Боловсролын үнэмлэхийн скан хуулбарыг нотариатаар батлуулсан орос хэлний орчуулгын хамт ирүүлэх.
- Боловсролын үнэмлэх эсвэл мэргэжлийн баримт бичиг байхгүй тохиолдолд гадаадын иргэнд суралцаж байсан сургуулиас олгосон сүүлчийн жилийн аттестацийн дунг харуулсан баримт бичиг гаргаж өгөх (оросын боловсролын стандарттаар ажиллаж байгаа сургуульд 10 ангийн, монгол сургуулиудын хувьд 11 ангийн)
- Оюутнуудын хувьд сургалтын хэлтсийн тамгаар баталгажуулсан сургалтын бүх семестрийн аттестацийн дунг харуулсан баримт бичгийг орчуулгын товчоогоор баталгажуулсан орчуулгын хамт ирүүлэх.

• ГАДААДЫН БОЛОВСРОЛ ЭСВЭЛ ГАДААДЫН МЭРГЭЖЛИЙГ ЗӨВШӨӨРСӨН ТУХАЙ ГЭРЧИЛГЭЭ (баримтын скан хуулбар) –энэ нь гадаад улсын (Монгол Улсаас бусад) боловсролын үнэмлэхтэй горилогчдод хамаарна;

• АВТОРЕФЕРАТ (ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ЗАХИДАЛ) ЭСВЭЛ НИЙТЛЭЛҮҮДИЙН ЖАГСААЛТ-дээд боловсролын сургалтын программаар сурах хүсэлтэй горилогчдын хувьд. Энэ нь горилогчийн сонгосон чиглэлд тохирсон ординатур болон аспирантур (адъюнктур)-ын эрдэм шинжилгээний ажилтан, багш нарыг бэлтгэх программууд юм. Мөн горилогчийн сонгосон чиглэлтэй тохирсон сэдэв бүхий нийтлэлүүдийн жагсаалтыг гаргаж өгөх

Рефератын оршил хэсэг (ундэслэл бүхий захидал)-д горилогчийн дараах мэдээллийг оруулна: боловсрол (их дээд сургууль, факультет, мэргэжил буюу сурах чиглэл) боловсролын ба эрдэм шинжилгээний туршлагыг харуулсан боловсролын ба эрдэм шинжилгээний ажил (эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд гаргасан амжилтууд, эрдэм шинжилгээний хуралуудад оролцсон байдал, шинжлэх ухааны холбогдолтой өгүүлэл нийтэлсэн гэх мэт).

Реферат (ундэслэл бүхий захидал)-д

1. Сонгосон боловсролын программаар сурах сонирхолтой эсэх
2. Горилогчийн суралцах хүсэлтэй аспирантурын мэргэжлийн тодорхойлолт
3. Явуулсан эсвэл явуулахаар бэлтгэсэн судалгааны сэдэв
4. Олж авсан мэдлэгийг цаашдын мэргэжлийн үйл ажиллагаанд ашиглах хэтийн төлөв байдал зэргийг тусгана.

Дээрх мэдээлэл нь тухайн боловсролын байгууллагаас шинжлэх ухааны удирдагчийг урвдчилан сонгоход хэрэгтэй болох юм.

• ГОРИЛОГЧИЙН СУДАЛГАА, ШИНЖЛЭХ УХААНЫ ОЛЛОТ АМЖИЛТЫГ НОТОЛСОН БАРИМТ БИЧГИЙГ ИРҮҮЛЭХ (сүүлийн 2 жилд буюу 2023 оноос хойш)



**EDUCATION
IN RUSSIA**



• “БАКАЛАВР” ЭСВЭЛ “МЭРГЭШЛИЙН” түвшинд суралцах хүсэлтэй горилогчид портфолиод орос хэлээр хийсэн видео танилцуулгыг хавсралтаар оруулна (видео бичлэгийн үргэлжлэх хугацаа 2 минутаас дээшгүй байна).

Видео танилцуулгыг харилцан ярилцлагатай дүйцүүлэн үнэлнэ

Видео танилцуулга нь дараах зүйлийг агуулсан байна. Үүнд:

- Горилогчийн тухай ерөнхий мэдээлэл
- Сонгосон боловсролын программаар сурах сонирхолтой эсэх
- Ирэдүйн мэргэжлийн ажиллагаанд олж авсан мэдлэгээ ашиглах байдал

- “Соёл, урлаг” чиглэлээр суралцахаар хүсэлт гаргаж буй горилогчид өөрсдийн уран бүтээлүүдээ (видео, зураг, скан) хавсаргасан байх шаардлагатай. Эдгээр бүтээлүүдийн зураг, бичлэгийг Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй харах боломжтой нээлттэй цахим эх сууралжид байршуулсан байх ёстой.

БАРИМТ БИЧИГТ ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. Баримт бичгийг заавал өөр өөр файлд хийсэн байх
2. Цахим файл бүр өөрийн нэрэнд ирүүлсэн баримтын нэр орсон байна
3. Мэдээллийн системд баримт бичгийг зохистой байдлаар оруулахын тулд файлуудыг pdf форматаар оруулах
4. Оруулж буй бүх баримт бичгийн дүрс тод бөгөөд төвөггүй уншигдаж байвал зохино.
5. Скан хуулбаруудыг мэдээллийн систем дэх ГИС «ОРФИ» хэсэгт оруулбал зохино

Гадаад хэл дээр байгаа бүх баримт бичгийг орос хэлэнд хөрвүүлнэ!

Уралдаанд тавигдах шардлагад нийцээгүй баримт бичгийг уралдаанд хүлээж авахгүй !

Хавсралт 1.1

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ЧИГЛЭЛҮҮДИЙН ЖАГСААЛТ (ГОЛЛОХ ХИЧЭЭЛИЙГ ЗААСАН БАЙНА)

Бүлгийн №	Голлох хичээл	Чиглэлүүд
1	Физик + Математик	01 – Математика ба механик 02 – Компьютер, мэдээллийн шинжлэх ухаан 03 – Физик ба астрономи 05 – Дэлхийн тухай шинжлэх ухаан 07 – Архитектур /уран барилга/ 08 – Барилгын техник, технологи 09 – Информатик ба тооцолон бодох техник



		10 – Мэдээллийн аюулгүй байдал 11 – Электроник, радиотехник ба холбооны системууд 12 – Фотоника, багажийн үйлдвэрлэл, оптик ба биотехникийн систем ба технологи 13 – Цахилгаан- ба дулааны техник 14 – Цөмийн эрчим хүч, технологи 15 – Машины үйлдвэрлэл 16 – Физик техникийн шинжлэх ухаан, технологи 20 – Техно бүрхүүлийн аюулгүй байдал, байгал байгууламж 21 – Хавсралт геологи, уулын ажил, нефте хийн үйлдвэрлэл ба геодези 22 –Материалын технологи 23 – Газар дээрх тээврийн техник, технологи 24 – Нисэхийн ба пуужин сансрын техник 25 – Агаарын навигаци /залуур/ ба нисэхийн ба пуужин сансрын техникийн ашиглалт 26 – Усан онгоц, усан тээврийн үйлдвэрлэлийн техник, технологи 27 –Техникийн систем дэх удирдлага 28 – Нанотехнологи ба наноматериалууд
2	Хими + Биологи	30 – Суурь анагаах ухаан 31 – Клиник анагаах ухаан 32 – Эрүүл мэндийн тухай шинжлэх ухаан, урьдчлан сэргийлэх анагаах ухаан 33 – Фармаци /эм зүй/ 34 – Сувилахуй 35 – Хөдөө, ой, загасны аж ахуй 36 – Мал эмнэлэг, зоотехникийн ухаан 06 – Биологийн шинжлэх ухаан 19 – Биотехнологи
3	Хими + Математик	04 – Хими 18 – Химийн технологи 29 – Хөнгөн үйлдвэрлэлийн технологи
4	Орос хэл + Биологи	37 – Психологи /сэтгэл судлал/ 49 – Биеийн тамир, спорт
5	Нийгэм судлал + Орос хэл	40 – Хууль зүй 41 – Улс төрийн шинжлэх ухаан, бүс нутаг судлал 42 – Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл номын сангийн ажил 43 – Сервис ба аялал жуулчлал 44 – Боловсрол ба сурган хүмүүжүүлэх ухаан 45 – Хэл зүй, утга зохиол судлал 46 –Түүх ба археологи 47 – Философи, этик, шашин судлал 48 – Теологи /шашны сургаал/ 50 – Урлаг судлал



**EDUCATION
IN RUSSIA**



		51 – Соёл судлал, социо соёлын төслүүд 58 – Дорно судлал, африк судлал
6	Математик + Орос хэл	38 – Эдийн засаг, удирдлага 39 – Социологи, нийгмийн ажил
7	Урлагийн мэргэжил (Ажлын хэсгүүдэд ОХУ-ын Соёлын яам болон яамд хамаарах боловсролын байгууллагуудын төлөөлөгчдийг оруулна)	52 – Тайзны урлаг, утга зохиолын урлаг 53 – Хөгжмийн урлаг 54 – Дүрслэх ба хавсралт урлаг 55 – Дэлгэцийн урлаг

Хавсралт 2

ТЭТГЭЛЭГЭЭР СУРАЛЦУУЛАХ ГОРИЛОГЧДЫН СОНГОН ШАЛГАРУУЛАТЫН НЭГДҮГЭЭР ШАТАНД ДҮНГ ТООЦОХ ОЛИМПИАДУУДЫН ЖАГСААЛТ *

* сүүлийн 2 жилийн дүнг харгалзна, гэхдээ ялагч/шагналт байрыг нотолсон медаль эсвэл дипломтой байх.

No	Олимпиадын нэр	Олимпиадын нэр англи хэл дээр
1	Өсвөрчүүдийн байгалийн ухааны олон улсын лимпиад (МЕО)	International Junior Science Olympiad (IJSO)
2	Олон улсын математикийн олимпиад (ММО)	International Mathematical Olympiad (IMO)
3	Олон улсын физикийн олимпиад (МФО)	International Physics Olympiad (IphO)
4	Олон улсын биологийн олимпиад (МБО)	International Biology Olympiad (IBO)
5	Олон улсын химийн олимпиад (МХО)	International Chemistry Olympiad (IChO)
6	Олон улсын информатикийн олимпиад (МОИ)	International Olympiad in Informatics (IOI)
7	Олон улсын астрономи, астрофизикийн олимпиад (МОАА)	Olympiad on Astronomy and Astrophysics (IOAA)
8	Олон улсын астрономийн олимпиад (МАО)	International Astronomy Olympiad (IAO)
9.	Олон улсын «Open Doors»	Open Doors Olympiad



EDUCATION
IN RUSSIA



10	<p>ОХУ-ын Боловсрол шинжлэх ухааны яамны тушаалаар батлагдсан сурагчдын олимпиадын жагсаалт орсон олон улсын 1 ба 2 –р түвшний олимпиадууд (<u>Байгалийн ухааны олимпиадууд</u>: олимпиадын дүнг зөвхөн <u>Хавсралт 1.1.-ийн 1,2,3,4,6</u> дугаарын суралцах чиглэлийг сонгосон горилогчид тооцно)</p> <p><u>Хүмүүнлэгийн ухааны олимпиадууд</u>: олимпиадын дүнг зөвхөн <u>Хавсралт 1.1.-ийн 5, 6</u> дугаарын суралцах чиглэлийг сонгосон горилогчид тооцно *</p> <p>*Тухайн хичээлийн 75%-аас доошгүй дүн өмнөх боловсролын үнэмлэхэд орсон байх</p>	<p>International Olympiads of the I and II level, included in the list approved by the order of the Ministry of education</p>
----	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------



**EDUCATION
IN RUSSIA**



Хавсралт 3

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨРЛИЙГ ХАРГАЛЗАН ХУВИЙН ЖИНГЭЭР ХУВААРИЛАХ НЬ

	Тестын шалгалт	Боловсролын үнэмлэхийн уралдаан	Портфолио уралдаан (хувийн амжилтаар)	Харилцан ярилцлага	Урлагийн уралдаан
Бакалавр /мэргэшил (алс чанадад улс)					
Вариант 2	-	0,8	0,1	0,1	-
Магистр/ординатур					
Вариант 1	-	0,8	0,2	-	-
Аспирантур/адъюнктур					
Вариант 1	-	0,6	0,4	-	-
ТДБ					
Вариант 2	-	0,8	0,2	-	-
НБ					
Вариант 2	-	0,8	0,2	-	-
Бүх түвшин (урлагийн чиглэлүүд)					
Вариант 1	-	-	-	-	1
Боловсролын бүх түвшин (спортын чиглэл)					
Вариант 1	-	0,6	0,4	-	-

Хавсралт 4

ХОЁРДУГААР ШАТАНД ОРОЛЦОХ ГОРИЛОГЧДЫН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Анкет-өргөдөл


Дараах зүйлүүдийг зөв бөглөх талаар анхаарна уу:

- виз шаардлагатай эсэх түүнийг авах газар (гадаадын иргэн, иргэншилгүй хүмүүст хамаарна). Виз бүрдүүлж өөр улсад түүнийг авахын тулд горилогч тухайн улсад оршин суух үнэмлэх (эсвэл түр оршин суух зөвшөөрөрл)-ийн хуулбарыг гаргаж өгнө. Гэхдээ түүний хүчинтэй байх хугацаа нь виз нээлгэсэн өдрөөс хойш 3 сараас доошгүй байх бөгөөд орос хэлэнд орчуулсан байна.

- эх орон нэгтэн, дүрвэгч эсвэл хасгийн үр удамын эрх зүйн статустай байх (10 хэсэг). Аль нэг статусыг заасан тохиолдолд түүнийг нотлоа баримт бичиг гаргаж өгнө.



**EDUCATION
IN RUSSIA**



- хэсгийн нэгдэлд хамаарах тохиолдолд горилогч нь хасгийн нийгэмлэгийн атаманы бэлтгэл ангид суралцах зайлшгүй шаардлагатай эсэх үндэслэл бүхий тодорхойлот ба тус нийгэмлэгийн нэрснээс авсан сүлдэт тамга бүхий хуулга гаргаж өгнө.
- горилогчид байгаа (18 хэсэг) хүсч буй (22 хэсэг) боловсролын түвшний зөв эсэх
- суралцах чиглэл түүний зөв дугаарыг заах (24.1., 24.2. хэсгүүд)
- аспирантурын программаар суралцахаар төлөвлөж буй горилогчийн шинжлэх ухааны чиглэл мэргэжилийг заах (24.3 хэсэг)
- аспирантур, ассистентур-дадлагжих, ординатур зэрэг программаар суралцахаар төлөвлөж буй горилогчийн судалгааны сэдвийг заах (25 хэсэг). Горилогч нь бэлгэл ангид суралцахаар сонгосон тохиолдолд сэдвийг англи хэлээр зааж болно.
- давын өмнө суралцах дарааллын дагуу 6 сургуулийг заах (26 хэсэг)

Сонгох дүрэм: нэг холбооны тойиргоос 3 сургууль, Москва, Санкт-Петербург, Севастополь хотуудаас 2 дээшгүй сургууль сонгоно.

Хэрэв горилогч нь зөвхөн нэг сургууль сонгож тухайн сургууль нь түүнийг суралцуулхаас татгалзсан тохиолдолд горилогч ОХУ-д суралцах боломжгүй болно гэдэгт анхаарна уу.

- бэлтгэл анги (факультет 28 хэсэг)-д суралцах зайлшгүй шаардлагатай эсэх
 - 35-р хэсэгт горилогчийн гарын үсэг огноо байгаа эсэх
 - анкетын бүх хуудас бүрэн байгаа эсэх (5 хуудас)
 - анкетанд тусгасан мэдээллийн өгөгдхүүн систем дэх өгөгдхүүнтэй тохирч буй эсэх.
- Системд байгаа өргөдөлд горилогч эсвэл төлөөлгч нь өөрчлөлт оруулах бол анкетын шинэ файлыг блөж горилогчийн гарын үсгээр баталгаажуулна.

Дээр заасан мэдээллийг шалгаж дууссаны дараа 36-р хэсэгт байх анкет –өргөдөлд мэдээллийн бүрэн хийгээд үнэн зөвийг шалгасан төлөөлгч гарын үсэг зурж огноог тэмдэглэнэ.

2. Горилогчийг хэн болохыг нотлох үнэмлэхний скан хуулбар. Энэ нь Оросын Холбооны Улсад хүлээн зөвшөөрөгдсөн байвал зохино.

Горилогчийн паспортын хүчинтэй байх хугацаа нь хил нэвтрэх огнооноос хойш 1,5 жилээс доошгүй байна /2027 оны 3-р сарын 1/. Орчуулгын товчоогоор баталгаажуулсан баримтын орчуулгыг гаргаж өгөх шаардлагатай.

Паспортын скан хуулбар орчуулгын товчоогоор баталгаажуулсан орос хэлний орчуулгыг тусдаа хоёр цахим баримтаар ирүлнэ.

Хэд хэдэн улсын иргэн бол бүх паспортын скан хуулбарыг гаргаж өгнө.

Баримт бичгийн дурсэд хэвлэсэн цаасны зах орсон байвал зохино. Хуудасны зах бол баримт бичгийн салшгүй хэсэг бөгөөд захыг хайчлахыг хориглоно. Оруулж буй бүх баримт бичгийн дурс чанартай (тод) байж баримтын агуулгыг ойлгоход төвөггүй үншигдаж байвал зохино.

3. Боловсролын үнэмлэхийн хуулбар .


Диплом/аттестатын хамт үзсэн хичээл сурлагын дун бүхий хавсралт/ транскриптыг ирүүлэх.

Үнэмлэхийн эх хувийн скан хуулбарын хамт орчуулгын товчоогоор баталгаажуулсан орос хэлэнд хөрвүлсэн орчуулгыг ирүүлэх шаардлагатай

Боловсролын үнэмлэх эсвэл мэргэжлийн баримт бичиг байхгүй тохиолдолд гадаадын иргэн сурч байсан боловсролын байгууллагаас олгосон сүүлчийн жилийн аттестацийн дунг



**EDUCATION
IN RUSSIA**



харуулсан баримт бичиг гаргаж өгөх (10 ангийн сурлага (11-р ангийн сургалттай бол), 11-р ангийн сурлага (12-р ангийн сургалттай бол).

- 1-2-р курсын оюутнуудын хувьд сургалтын хэлтсийн тамга бүхий сурлагын тухай тодорхойлолт (дундаж оноо 2,8-аас доошгүй буюу "сайн"), орчуулгын товчоогоор баталгаажуулсан орчуулгын хамт .

- Гэрээний дагуу оросын их дээд сургуулийн бэлтгэл ангид гэрээгээр суралцагсадын хувьд 1-р семестрийн орос хэл, чиглэлийн (сургалтын чиглэлээр: хүмүүнлэгийн, техникийн, анагаах ухааны, эдийн засгийн гэх мэт) хичээлийн сурлагын тодорхойлолт, бүрэн дунд боловсролын аттестатын хуулбар орчуулгын товчоогоор баталгаажуулсан орос хэлэнд хөрвүүлсэн орчуулгын хамт.

4. Гадаадын боловсрол эсвэл гадаадын мэргэжлийн зэргийг хүлээн зөвшөөрсөн тухай гэрчилгээ

Гадаадын боловсрол эсвэл гадаадын мэргэжлийн зэргийг хүлээн зөвшөөрсөн тухай гэрчилгээтэй тохиолдолд уг баримт бичгийн скан хуулбарыг ирүүлэх шаардлагатай (гадаад улс /Монгол Улсаас гадна/-ын боловсролтойг нотолсон үнэмлэх бүхий горилогчийн хувьд)

5. Эрүүл мэндийн тодорхойлолтын хуулбар

ОХУ-д эрүүл мэндийн хувьд суралцах эс суралцах мэдээлэл бүхий горилогчийн эрүүл мэндийн ерөнхий дүгнэлт агуулсан элсэлтийн жилд хийсэн үзлэгийн огноотой эрүүл мэндийн тодорхойлолт (У-О86 маягт)-ын скан хуулбар байх ёстой. Англи эсвэл орос хэлнээс бусад хэлээр бичигдсэн эрүүл мэндийн тодорхойлолт ирүүлсэн тохиодолд түүний орос хэлэнд хөрвүүлсэн орчуулгыг ирүүлэх ёстой (нотариатаар баталгаажуулах шаардлагагүй).

А) В, С гепатит, сурьеэ өвчингүй нотолсон эрүүл мэндийн тодорхойлолтын хуулбар

Гадаадын иргэн В, С гепатит, сурьеэ өвчингүй болохыг нотолсон эрүүл мэндийн тодорхойлолтын скан хуулбартай байх ёстой. Уг тодорхойлолтыг суралцах хүсэлт гаргасан тухайн жилийн 9-р сарын 1-ээс хойш гаргаж өгсөн байвал зохино. Гадаадын иргэн В, С гепатит, сурьеэ өвчингүй болохыг нотолсон эрүүл мэндийн тодорхойлолтын хамт түүний орос хэлэнд хөрвүүлсэн орчуулгыг ирүүлнэ (нотариатаар баталгаажуулах шаардлагагүй).

Б) Гадаадын иргэн ХДОХВ/ ДОХ-гүй нотолсон эрүүл мэндийн тодорхойлолтын скан хуулбартай байх ёстой. Гадаадын иргэн ХДОХВ/ ДОХ-гүй нотолсон эрүүл мэндийн тодорхойлолтын хамт түүний орос хэлэнд хөрвүүлсэн орчуулгыг ирүүлнэ

6. Хувийн мэдээллийг боловсруулах, шилжүүлэх хадгалах тухай горилогчийн зөвшөөрөл.

Файлыг тусдаа баримт хэлбэрээр орос эсвэл англи хэлээр үйлдэж горилогчийн гарын үсгээр баталгаажуулна.

7. Автореферат (үндэслэл бүхий захидал), нийтлэлүүдийн жагсаалт

Дээд боловсролын сургалтын программ- ординатур, аспирантур (адъюнктур) зэрэг программаар сурах хүсэлтэй горилогчид сонгосон мэргэжилд нийцсэн сэдэв бүхий нийтлэлүүдийн жагсаалт эсвэл автореферат (үндэслэл бүхий захидал) гаргаж өгнэ . Реферат (үндэслэл бүхий захидал)-ын оршилд горилогчийн дараах мэдээллийг оруулна: боловсрол (их дээд сургууль, факультет, мэргэжил буюу сурах чиглэл) боловсролын ба эрдэм шинжилгээний туршлагыг харуулсан боловсролын ба эрдэм шинжилгээний ажил (эрдэм шинжилгээний



EDUCATION
IN RUSSIA



бүтээлийн уралдаанд гаргасан амжилтууд, эрдэм шинжилгээний хуралуудад оролцсон байдал, шинжлэх ухааны холбогдолтой өгүүлэл нийтэлсэн гэх мэт).

8. Реферат (үндэслэл бүхий захидал)-д дараах зүйлийг тусгана:

1. Сонгосон боловсролын программаар сурах сонирхолтой эсэх
2. Горилогчийн суралцах хүсэлтэй аспирантурын мэргэжлийн тодорхойлолт
3. Явуулсан эсвэл явуулахаар бэлтгэсэн судалгааны сэдэв
4. Олж авсан мэдлэгийг цаашдын мэргэжлийн үйл ажиллагаанд ашиглах хэтийн төлөв байдал.

Дээрх мэдээлэл нь тухайн боловсролын байгууллагаас шинжлэх ухааны удирдагчийг урвдчилан сонгоход хэрэгтэй болох юм.

9. Сонгон шалгаруулалтын үр дүнгийн скан хуулбарыг бүртгэлийн комисс хавсралтаар оруулна.

Горилогч нь үндэсний олимпиадын шагналт эсвэл ялагч байвал түүнийг нотлох баримт бичгийн хуулбарыг ирүүлнэ.

10. Бусад баримт бичиг

Горилогчийн хувийн амжилтыг нотолсон бусад баримт бичиг

Баримт бичигт тавигдах өрөнхий шаардлагууд

Баримт бичгийг тусдаа өөр өөр файлаар ирүүлэх.

Цахим файл бүрийн нэрэнд ирүүлэх баримт бичгийн нэр туссан байх ёстой.

Баримт бичгийн мэдээллийн системд зөв оруулахын тулд файлыг pdf-форматыг ашиглах

Оруулж буй бүх баримт бичгийн дурс чанартай (тод) байж баримтын агуулгыг ойлгоход төвөггүй уншигдаж байвал зохино.

Баримт бичгийг скан хуулбарыг мэдээллийн системийн ГИС "ОРФИ" зохих хэсгүүд рүү оруулах шаардлагатай